



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүн батлах
тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 2.15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмэгтэйчүүдийн хавдар судлал, хүүхдийн сувилахуй судлалын төрөлжсөн мэргэшлийн сургалтыг 2014-2015 оны хичээлийн жилд төгсөгчдөөс шалгалт авах улсын шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Шалгалтыг журмын дагуу хараат бус, ил тод зохион байгуулж, тайланг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлд 2015 оны 6 дугаар сарын 30-ны дотор нэгтгэн хүргүүлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/-т даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080816

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 10 өдрийн
᠒᠓᠓ дугаар тушаалын хавсралт

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХАВДАР СУДЛАЛ, ХҮҮХДИЙН СУВИЛАХУЙ СУДЛАЛЫН
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫГ 2014-2015 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД
ТӨГСӨГЧДӨӨС ШАЛГАЛТ АВАХ УЛСЫН ШАЛГАЛТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Сургалтын чиглэл	Комиссын бүрэлдэхүүний чиг үүрэг	Овог нэр	Албан тушаал, эрдмийн зэрэг, цол
1.	Эмэгтэйчүүдийн хавдар судлал	Дарга	Р.Сандуйжав	АШУҮИС-ийн багш, АУ-ны доктор
2.		Нарийн бичгийн дарга	М.Адилсайхан	АШУҮИС-ийн багш, АУ-ны доктор
3.		Гишүүд	Д.Авирмэд	АШУҮИС-ийн багш, АУ-ны доктор, Монгол Улсын гавьяат эмч
4.			Э.Амарсанаа	ХСҮТ-ийн эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эрхлэгч, АУ-ны доктор
5.			Ц.Бадамсүрэн	ХСҮТ-ийн Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга, АУ-ны доктор
6.	Хүүхдийн сувилахуй судлал	Дарга	Д.Солонго	АШУҮИС-ийн багш, Сувилахуйн ухааны доктор
7.		Нарийн бичгийн дарга	П.Пүрэвдаваа	ЭХЭМҮТ-ийн Сувилахуйн албаны дарга
8.		Гишүүд	Д.Нямсүрэн	Монголын сувилагчдын нийгэмлэгийн тэргүүн, Сувилахуйн зөвлөх зэрэгтэй
9.			Ц.Тунгалаг	ЭМХТ-ийн Сувилахуй, тусгай мэргэжилтний сургалт, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн